

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны
1/1449 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

- 1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны хэрэгжилт
- 1.2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны хэрэгжилт
- 1.3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт
- 1.4.Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт
- 1.5.Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний 2025 оны хэрэгжилт

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

- 2.1.Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайлан
- 2.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт

ГУРАВ.БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

- 3.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ
- 3.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ
- 3.3.Шударга байдлын түвшний үнэлгээ
- 3.4.Хэрэглэгчийн үнэлгээ

ДӨРӨВ.ОНЦЛОХ АЖЛУУД, ДҮГНЭЛТ

- 4.1.2025 оны онцлох ажлууд
- 4.2.Ерөнхий дүгнэлт

ТАВ.ХАВСРАЛТ

- Хавсралт 1. УБЕГ-ын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан
- Хавсралт 11. Худалдан авах ажиллагааны тайлан

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025.12.12

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025 онд хэрэгжүүлсэн Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд болон тус байгууллагаас дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлыг хамруулж үр дүнг үнэлэв.

**НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭ**

1.1.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025 онд 3 эрх зүйн актын 30 зүйл заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласан.


Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт	Зүйл, заалтийн тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ			
			/-/	30	70	90-100
1	Засгийн газрын тогтоол	5	-	-	-	5
2	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	8	-	-	1	7
3	Засгийн газрын албан даалгавар	17			1	16
Нийт		30	-	-	2	28

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт “бүрэн хэрэгжсэн” буюу 98.3 хувьтай үнэлэгдэв.

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2024 он	2025 он	Өсөлт, бууралт
99.8%	98.3	-0.5%



Хяналтаас хасуулах заалтын талаар:

- Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160, №2 (Энэ тогтоолоор өгөгдсөн

үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.)

Санал: Хяналтад байсан асуудлыг Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагаар шалгагдаж, холбогдох үйл ажиллагаа явагдаж байгаа тул хяналтаас хасах саналтай.

- Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215 №3 (Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэг болон киоск машинаар дамжуулан олгох боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (П.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай)

Санал: Монгол Улсын 16 нас хүрсэн 1,774,719 иргэнд тоон гарын үсэг олгогдсон. УБЕГ болон бусад байгууллагын 1,600 гаруй киоск машин ашиглан үнэгүй үйлчилгээ үзүүлж байна. Үүрэг биелэгдсэн тул хяналтаас хасуулах саналтай. (Тайланг хоёрдугаар хавсралтаас үзнэ үү.)

1.2.МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан 5.3."Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ" зорилтын хүрээнд дөрвөн арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Зорилт	Арга хэмжээ ний тоо	Гүйцэтгэлийн хувь							Дундаж	
		/-/	0	30	50	70	90	100	хувь	оноо
5.3. мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ:	12	-	-	2	-	-	-	8	94	4.7

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл хэрэгжилт "үр дүнтэй" буюу 94 хувиар үнэлэгдэв. (Тайланг гуравдугаар хавсралтаас үзнэ үү.)

1.3. ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний Засаглалын бодлого хэсгийн 4.2.3.1."Чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж,

төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгож, төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.”, 4.3.1.5.”Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.”, 4.3.3.6. Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулж, бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ.” гэсэн 3 зорилтод хамаарах 6 арга хэмжээг хяналтад авч, тэдгээрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Хяналтад авсан 8 арга хэмжээний биелэлтэд өгсөн үнэлгээг хүснэгтэд харуулав:

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ						Дундаж Хувь
			0	30	50	70	90	100	
1	4.2.3.1. Чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгож, төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.	3	-	3	-	-	-	-	30
2	4.3.1.5. Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.	2	-	1	-	-	-	1	65
3	4.3.3.6. Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулж, бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ.	1	-	-	-	-	-	1	100.0
НИЙТ		6	-	4	-	-	-	2	65

Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 65 хувьтай үнэлэгдэв. (Биелэлтийг дөрөвдүгээр хавсралтаас үзнэ үү.)

1.4. УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 35 дугаар “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого хэсгийн 4.1.2.”Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулна.” гэсэн зорилтод хамаарах 1 арга хэмжээг хяналтад авч, тэдгээрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ						Дундаж Хувь
			0	30	50	70	90	100	
1	4.1.2.12.Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох	1	-	-	-	-	-	1	100
	НИИТ	1	-	-	-	-	-	1	100

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 100 хувьтай үнэлэгдэв. (Биелэлтийг тавдүгээр хавсралтаас үзнэ үү.)

1.4.САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 55 дугаар “Яамдын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг батлах тухай” тогтоолын 5 дугаар хавсралтад заасан Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамаарах 2 үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг 100 хувь буюу 5.0 оноогоор дүгнэв.

№	Үзүүлэлт	Зорилтот түвшин 2025 он	Гүйцэтгэл 2025 он	Үнэлгээ
1	Цахим хэлбэрт шилжүүлсэн хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо	276,227	276,227	100%
2	Цахим хэлбэрт шилжүүлсэн эд хөрөнгийн хувийн хэргийн тоо	1,430,422	1,430,422	

(Салбарын хөгжлийн үзүүлэлтийг зургаадугаар хавсралтаас үзнэ үү.)

ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ 2.1.БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 41 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 92.6 хувийн биелэлттэй байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт	Зүйл, заалт ийн тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ						Дундаж Хувь
			/-/	30	50	60-70	80-90	95-100	
1	Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.	11	1				2	8	96.2%
2	Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.	10			1	1	2	6	88.2%
3	Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг	7		1			1	5	87%

	ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.								
4	Зорилт 4. Гадаад улстай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	3		1			2	77%	
5	Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.	3					3	100%	
6	Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1					1	100%	
7	Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.	6					6	100%	
Нийт		41	1	2	1	1	5	31	92.6%


Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээ	Хувь
2	2.3.Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх (автомашин) зөөврийн тоног төхөөрөмжийн программ хангамжийг сайжруулах, тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх	53
3	2.7.Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	65
5	3.3. Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хангах бүртгэлийн хяналтын систем нэвтрүүлэх	30
6	4.3.Бүртгэлийн зөрчлийг багасгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомжийн шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх	30

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

(Тайланг долоодугаар хавсралтаас үзнэ үү.)

2024 он	2025 он	Өсөлт, бууралт
92.55%	92.60%	0.05%



2.2.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР, 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024.11.12-ны өдрийн А/180 дугаар тушаалын хавсралтаар “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлан хэрэгжүүллээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж хувь
		/-/	30	50	70	100	
1	24	-	-	-		24	100

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2024 он	2025 он	Өсөлт, бууралт /+, -/
100%	100%	-



(Биелэлтийг найм, есдүгээр хавсралтаас үзнэ үү.)

ГУРАВ .БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ 3.1.БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ


Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн дагуу 5 ангиллын 68 төрлийн нээлттэй мэдээллийг байршуулан ажиллахаас Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамаарал бүхий мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад 48 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй улирал тутам тогтмол байршуулан ажиллаж байна. Shilen.gov.mn-д байршуулсан Улсын бүртгэлийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод үнэлгээгээр 3 дугаар улирал 98 хувиар үнэлэгдсэн байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Шалгуур үзүүлэлт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/
1	Үйл ажиллагааны ил тод байдал	18	98
2	Хүний нөөцийн ил тод байдал	7	91
3	Төсөв санхүүгийн ил тод байдал	12	100
4	Үйлчилгээний ил тод байдал	6	100
5	Бусад	5	99
Нийт дундаж		48	98

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

2024 он	2025 он	Өсөлт, бууралт
96.7%	98%	1.3



(Тайланг <https://shilen.gov.mn/indexdetail?reportId=68b67fbc2b6b563ef16b57a6&active=68b659372b6b563ef16b566f&approvedDate=2025-11-04T12:31:49.218> үзнэ үү.)

3.2.ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын бүртгэлийн байгууллагын 22 нэгж “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2-т заасан нийтэд мэдээлэх 23 төрлийн 3,869 мэдээллийг байршуулахаас хугацаа 11 мэдээлэл хоцроосон байна. Биелэлт 99.7 хувь байна.


Энэ оны III улирлын байдлаар улсын бүртгэлийн байгууллагын хэмжээнд “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш” үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний нийт дүн 113,776.32 сая төгрөг, зарлагын мөнгөн гүйлгээний нийт дүн 23,775.47 сая төгрөгийн мэдээллийг байршуулан ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг олон нийтэд хуулийн хугацаанд бүрэн гүйцэт мэдээлж төсвийн ил тод байдлыг хангаж, иргэдийн төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, хуулийн үндсэн зорилтыг ханган Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 “Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл” агуулгын хүрээнд улсын бүртгэлийн ерөнхий газрын албан цахим хуудас <http://burtgel.gov.mn>-д <https://shilendans.gov.mn/organization> холбоосыг байршуулсан.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээ байршуулалт 99.7 хувь байна.

Өмнөх оны үнэлгээтэй харьцуулбал:

Тайлант он	Жилийн дундаж хувь	Оноо
2024 он	100%	5
2025 он	99.7%	4.99



Шилэн дансны цахим хуудсанд:

- Төсвийн гүйцэтгэлийн 11 төрлийн мэдээлэл;
- хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл;
- Бусад 7 төрлийн мэдээллийг сар бүр, хагас жил бүр, жил бүр, тухай бүр хугацааны давтамжтайгаар байршуулсан.

Өмнөх жилийн мөн үеэс 0.3 хувиар буурсан бөгөөд салбарын хэмжээнд нийт 11 мэдээллийг цахим системд хугацаа хоцроон байршуулсан үзүүлэлттэй байна. Цаашид цахим системд хугацаа хоцроон байршуулахгүй байх талаар урьдчилан анхааруулах арга хэмжээ авч хуулийн хугацаанд бүрэн байршуулж мэдээлэхээр ажиллаж байна. (Биелэлтийг арвдугаар хавсралтаас үзнэ үү.)

3.3.ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

Авлигын эсрэг үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас сонгон шалгаруулсан "Бодлогын шийдэл" ТББ-аас Шударга байдлын үнэлгээг 2024 оны 7,8,9 дүгээр сард УБЕГ-т хийгдсэн болно. Үнэлгээний нэгдсэн тайланд 78.4 хувиар үнэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оноос 2 хувиар буурсан үзүүлэлтэй. Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Авлигатай тэмцэх газарт хуваарийн дагуу хүргүүлж үнэлгээ хийгдэнэ.

3.4.ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх ажлыг гүйцэтгүүлэхээр “Мянганы өглөө” НҮТББ-ыг сонгон шалгаруулж, 2025.11.15-ны өдрөөс 2025.12.10-ны өдрүүдэд хийхээр гэрээ байгуулан хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил хийгдэж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнд тулгуурлан санал зөвлөмжийг ирүүлснийг үйл ажиллагаандаа тусган анхаарч, ирэх оны төлөвлөгөөнд холбогдох арга хэмжээг тусган авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ОНЦЛОХ АЖЛУУД

4.1.2025 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

Улсын бүртгэлийн ерөнхий газар 2025 онд дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэв:Үүнд:

1. Улсын бүртгэлийн байгууллага “Алтан гадас” одонгоор шагнагдав.

Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн тохиолдуулан 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны ... дугаар зарлигаар Улсын бүртгэлийн байгууллагыг төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнав.

2. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай” хөтөлбөр батлагдав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/206, байгууллагын даргын 2024 оны А/180 дугаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай”, 2025 оны А/96, А/97 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. УБЕГ-ын архивын зориулалттай барилга байгууламж болон албан хаагчдын орон сууцны барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Буянт шарга констракшн”-тай байгуулсан. Албан хаагчдад зориулсан орон сууц нь нийт 2 блок, 16 давхар бөгөөд нийт 15,660 м.кв талбайг хамарна. Харин архивын зориулалттай барилга нь 1,500 м.кв талбайтай, хоёр давхар (зоорины давхартай) байхаар төлөвлөгдсөн, барилгын нийт өртөг нь 6 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч “Буянт Шарга Констракшн” ХХК 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж гүйцэтгэхээр болсон. Улсын бүртгэлийн ерөнхий газрын архивын зориулалттай барилга болон албан хаагчдад зориулсан орон сууцны барилгын шав тавих ёслолыг 2025 оны 06 дугаар 05-ны өдөр зохион байгуулав.

3. Кибер аюулгүй байдлын тухай хууль, Мөнгө угаах, терроризмтой тэмцэх үндэсний зөвлөлийн зөвлөмж болон бусад бодлогын баримт бичгийн хүрээнд байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны “Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/45 дугаар тушаалаар Хяналт шалгалтын газрын дэргэд Кибер, аюулгүй байдлын хэлтэс байгуулсан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн

2023.09.22-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хариуцан ажиллах 2 албан хаагчийг байгууллагын даргын тушаалаар томилон, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

4. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд хандсан хэрэглэгчийн логийн бүртгэлийн программ хангамжийн нэвтрүүлэв.

Иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой бүх төрлийн мэдээлэлд хэн, хэзээ, ямар үйлдэл хийснийг бүрэн, тасралтгүй, засварлах боломжгүй хэлбэрээр хадгалах, хянах боломжтой лог бүртгэлийн программ хангамжийн бодлогын даалгаврыг боловсруулан, “Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдал болон мэдээллийн системийн үйлдлийн бүртгэл хөтлөх программ хангамжийг худалдан авах” ажлын хэсэг байгуулагдаж, техникийн тодорхойлолтыг батлуулан худалдан авах ажиллагааг 2025.06.13-ны өдөр tender.gov.mn цахим хуудсаар олон нийтэд нээлттэй зарлагдсан. Худалдан авах ажиллагааны үнэлгээгээр “ГӨҮ СМАРТ ТМ” ХХК-тай 2025.07.28-ны өдөр УБЕГ/2025/36 дугаар гэрээг байгуулан хамтран ажилласан. УБЕГ-ын даргын 2025 оны А/180 тоот тушаалаар лог бүртгэлийн программ хангамжийг хүлээн авах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд гэрээнд заасны дагуу тестийг явуулж, маягтын дагуу 2025.10.14-ний өдөр хүлээн авч хэрэглээнд нэвтрүүлээд байна.

5. “Монгол улсын суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, цахим шилжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөө” батлуулав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүх газар хэлтсүүдээс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэмжлэгтэйгээр гүйцэтгэх ажлын санал авч нэгтгэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлж “Монгол улсын суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөө” батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тухайлбал,

- Хуулийн этгээдийн нэрийг хиймэл оюун AI ашиглан баталгаажуулахаар Чимэгэ системс ХХК-тай уулзалт зохион байгуулж, бодлогын даалгавар боловсруулан ЦХИХХЯ-нд хүргүүлээд байна.
- Хуулийн этгээдийн дотоод сүлжээ “ERS” системийг И-Бизнес цахим системтэй холбох, бодлогын даалгавар боловсруулан ажиллаж байна.
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай хамтарсан “Монгол улсын суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөө” батлуулан Хуулийн этгээдийн гэрчилгээг блокчейн технологи ашиглан баталгаажуулах зэрэг болно.

6. Төрийн архивын үйл ажиллагаанд улсын үзлэг байгуулах шийдвэр гарлаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дах заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтад 2025 оны 3, 4 дүгээр улиралд багтаан улсын үзлэг зохион байгуулахаар шийдвэрлэж комиссын бүрэлдэхүүн болон үзлэгийн удирдамжийг батлагдсан.

Энэ хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2025 оны 12 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, төрийн байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшинг үнэлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, дүгнэлт гаргах, цаашид авах

арга хэмжээний талаар зөвлөмж, чиглэл өгч ажиллалаа. Улсын үзлэгийн үнэлгээ 95 хувьтай үнэлэгдэв.

4.2.ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

УБЕГ-ын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг харуулбал:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо /5-с/
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	98.3	0.46	4.8
	2.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	65		
	3.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт	94		
	4.Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний биелэлт	100		
	5.Салбарын хөгжлийн үзүүлэлт	100.0		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	92.6	0.19	
	2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100.0		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод нээлттэй байдлын үнэлгээ	98	0.3	
	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	99.7		
	3.Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	-		
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		95	0.95	

УБЕГ-ын 2025 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 95 хувь буюу 4.7 оноотой дүгнэгдсэн нь 2024оны үнэлгээнээс 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм.

Цаашид бууралттай арга хэмжээний хүрээнд тодорхой ажил зохион байгуулж, төлөвлөлтөд анхаарч, гүйцэтгэлийг бүрэн хангуулж ажиллах болно.

--oOo--